



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/140

Эрдэнэт

### Улсын онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, 29.1.5 “в”, 29.1.6 “л”, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 27, 45 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2021 оны 07, 08 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт Коронавируст халдвар /Ковид-19/-ын эх үүсвэр нь тодорхойгүй тохиолдол илэрсэн тул аймгийн хэмжээнд байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн үйл ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 04 дүгээр сарын 07-ны өдрийг дуустал хугацаанд түр зогсоосугай.

3. Зорчигч, тээврийн хэрэгслийн Орхон аймагт ирэх, аймгаас гарах хөдөлгөөнийг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 04 дүгээр сарын 07-ны өдрийг дуустал хугацаанд түр хязгаарласугай.

4. Баян-Өндөр, Жаргалант сумдын хэмжээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулах түүгээр үйлчлэх үйл ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 04 дүгээр сарын 07-ны өдрийг дуустал хугацаанд оройн 18.00 цагаас өглөөний 10.00 цаг хүртэл хугацаанд хориглосугай.

5. Диска, паб, караоке, пиво баарны үйл ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 04 дүгээр сарын 07-ны өдрийг дуустал хугацаанд түр зогсоосугай.

6. Байгууллага салбарынхаа хэмжээнд ариутгал, халдваргүйтгэлийг зохион байгуулж, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа (спорт зааланд тоглох, сургалт, семинар, цугларалт, уншлага, хэлэлцүүлэг, РС тоглоом, фитнес, спиннинг нийтийн бүжиг)-г 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 04 дүгээр сарын 07-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулахгүй байхыг иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад даалгасугай.

7.Эрдэнэт хотын хэмжээнд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоон, хяналтыг эрчимжүүлж, эмнэлэг, онцгой байдал, тагнуул, цагдаагийн байгууллага, хог тээвэрлэлтийн тээврийн хэрэгслийг хязгаарлалтгүйгээр, 2021 оны 03 дугаар сарын 25, 27, 29, 31, 04 дүгээр сарын 01, 03, 05, 07-ны өдрүүдэд сондгой тоогоор төгссөн дугаартай, 03 дугаар сарын 26, 28, 30, 04 дүгээр сарын 02, 04, 06-ны өдрүүдэд тэгш тоогоор төгссөн дугаартай тээврийн хэрэгслүүдийг замын хөдөлгөөнд оролцуулах, байгууллагуудын ажилтан, албан хаагчдын хувийн тээврийн хэрэгслийг өглөө 07.00-09.00, орой 17.00-20.00 цагийн хооронд зөвхөн гэр-ажил-гэр гэсэн маршрутын дагуу замын хөдөлгөөнд оролцуулан хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу)-т үүрэг болгосугай.

8.Орхон аймаг, Эрдэнэт хотод орж, гарч, дамжин өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тавих хяналт, ажлын зохион байгуулалтыг сайжруулж, албан ёсны хяналтын постоор орж ирээгүй зөрчил гаргасан тээврийн хэрэгслийг журамлах, жолооч, зорчигчдод холбогдох хариуцлага тооцох, тусгаарлах ажлыг зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Тагнуулын газар (М.Очирбат), Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Бат-Өлзий), Мал эмнэлгийн газар (П.Эрдэнэжаргал), Авто тээврийн төв (Г.Ядмаа), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр) нарт даалгасугай.

9.Энэхүү захирамжийг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Авто тээврийн төв (Г.Ядмаа), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр) нарт үүрэг болгосугай.

10.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүй дэмжлэгээр ханган, тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч А.Түвшинжаргал, аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Ганбаатар нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  С.БАТЖАРГАЛ